

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 20 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт



“Газар тариалан” хөтөлбөр

Нэг: “Газар тариалан” хөтөлбөр хэрэгжүүлэх нийтлэг үндэслэл

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай болон Тариалангийн тухай хууль, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “Органик хүнсний тухай” хууль, “Эрүүл хүнс - Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр, 2017 оны 223 дугаар тогтоолоор батлагдсан “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөр, “Атрын 3-р” аяны хүрээнд хүнсний ногоо, жимс жимсгэний нэр төрөл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, Ховд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн зорилт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийн хүрээнд иргэд газар өмчлөх, эзэмших, тариалан эрхлэх эрх зүйн шинэ орчин буй болсон нь өрхийн орлогыг нэмэгдүүлэх хамгийн тааламжтай нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Тариалангийн тухай хуулийн 21.1 дэх заалт болон Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.39-т “..үр тариа, төмс, гол нэрийн хүнсний ногоог 100 хувь, таримал тэжээлийн 50 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангана” гэж, 2.41-д “.. үрийн сорт чанарыг сайжруулах замаар га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ” гэж, 2.44-т “.. өвөл, зуны хүлэмжийн загвар, цогцолбор аж ахуйг хөгжүүлж, хот, суурины хүн амыг шинэ ургацын ногоогоор тогтвортой хангана” гэж заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор “Газар тариалан” хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр: Газар тариалангийн үйлдвэрлэлийн өнөөгийн түвшин

Газар тариалангийн оргил үе 1988 онд төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооны үед 9500 га талбайд тариалалт хийснээс 5600 га-д малын тэжээлийн ургамал, 3200 га-д үр тариа, 370 га-д төмс, 330 га-д хүнсний ногоо тариалж байсан байна. Тухайн үед усалгаатай тариалан эрхэлж байсны 47.5 хувь буюу 4514 га нь инженерийн хийцтэй услалтын систем байсны дотор Эрдэнэбүрэн сумын 1700 га, Алтай сумын Боомын амны 757 га, Булган сумын Хар үзүүр, Давхар эргийн 601 га, Дарви сумын Голын адаг, Хойд голын 532 га, Буянт сумын Шаргуугийн 300 га-гийн инженерийн услалтын системүүд хамгийн том нь байсан юм. Инженерийн услалтын систем байхгүй ч Мянгад,

Мөст, Чандмань, Жаргалант сум нэгдлүүд тус бүр 190-217 га талбайд усалгаатай тариалан эрхэлж байсан.

Манай аймгийн хувьд газар тариалангийн үйлдвэрлэл хамгийн эрчимтэй хөгжиж байсан жилүүдэд 12 услалтын системийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байжээ.

Зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа услалтын томоохон системүүдийг хувьчлан авсан компаниуд орлогоороо үйлдвэрлэлийн зардлаа нөхөж ашигтай ажиллаж чадахгүй болсноос өр зээлд орж, бороожуулагч төхөөрөмж, машин, техникээ худалдан банкны өрөө төлсөөр үйлдвэрлэл, ялангуяа малын тэжээл, үр тарианы үйлдвэрлэл улам буурсан байна.

Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоох ажлын хүрээнд газар тариалан бүхий сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн нийт 13 сумын 24375,3 га талбайг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 03 дугаар сарын 13-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор газар тариалангийн бүс нутаг болгон тогтоосон.

Ургац хураалтын 2018 оны эцсийн дүнгээр үр тариа 225.9 га-гаас 373,9 тн, төмс 682.5 га-гаас 9234,6 тн, хүнсний ногоо 917.4 га-гаас 11477,3 тн, малын тэжээл 397 га-гаас 1726,5 тн, нийт 2232.1 га-гаас 22812,3 тн ургац хураан авсан хэмжээг 1988 оны тариалалттай харьцуулахад үр тариа 2974,1 га-гаар буюу 92,9 хувиар, тэжээлийн ургамал 5203 га буюу 92,9 хувиар буурч, харин төмс тариалалт 312,5 га-гаар буюу 84,4 хувиар, хүнсний ногооны тариалалт 587,4 га-гаар буюу 178 хувиар тус тус нэмэгдсэн байна. Зах зээлийн эдийн засагт шилжсэнээр жижиг аж ахуй нэгж, хувь хүмүүсийн бие даан төмс, хүнсний ногоо тариалах сонирхол, тариалалтын хэмжээ нэмэгдсэн байна.

Гурав: Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь төмс, хүнсний ногоо, үр тариа, тэжээлийн ургамал, жимс, жимсгэний усалгаатай тариаланг хөгжүүлж, үрийн аж ахуй байгуулж, үр үржүүлэх, өрх, фермерийн аж ахуй нэгжүүд хүлэмжийн аж ахуйг эрхлэх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хүнсний хангамжийг сайжруулахад оршино.

Дөрөв: Хөтөлбөрийн зорилт

Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ.

4.1. Хөрс хамгаалах технологийг нэвтрүүлж, төмс, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуйн тариалалтыг нэмэгдүүлэх, хадгалах нөхцөлийг сайжруулж худалдан борлуулах

4.2. Үр тариа, тэжээлийн ургамал, жимс жимсгэнэ тариалалтыг нэмэгдүүлэх, орчны дэд бүтцийг сайжруулж кластераар хөгжүүлэх:

4.3. Газар тариалангийн талбайнуудын услалтын системийн усан хангамжийг нэмэгдүүлэх, шинээр ус хуваарилах байгууламж байгуулж, усны алдагдлыг багасгах усалгааны системүүдийг нэвтрүүлэх;

4.4. Газар тариалан эрхлэгчдийн зохион байгуулах чадавхыг сайжруулах, сургалт, зөвлөгөөнд хамруулж, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах

4.5. “Ховд агропарк” зорилтот төслийн хүрээнд хөдөө аж ахуйн техник дундын үйлчилгээний төв байгуулах, техникийн туслалцаа үзүүлэх “Мэргэжлийн баг” байгуулж, тариаланчдын мэргэжлийн чадавхыг сайжруулах, хяналт тавих

4.6. Үр үржүүлгийн аж ахуй байгуулах, ургамал хамгааллын арга хэмжээг сайжруулах

Тав: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.1. Хөрс хамгаалах технологийг нэвтрүүлж, төмс, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуйн тариалалтыг нэмэгдүүлэх, хадгалах нөхцөлийг сайжруулж худалдан борлуулах зорилтын хүрээнд:

5.1.1. Тариалангийн талбайг хөрсний элэгдэл, эвдрэлээс хамгаалж ойн зурвас байгуулах, хөрс хамгаалах технологийг нэвтрүүлэх.

5.1.2. Шинэ төрлийн таримал ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх. /салат, цэцэгт, броколи байцаа, сармис, амтат болон гашуун чинжүү, үнэрт, навчит ногоо/

5.1.3. Ховдын органик брэнд бүтээгдэхүүн буй болгох, уламжлалт нэрийн бүтээгдэхүүнийг /тарвас, төмс, сармис, арвай /Сутай сорт /амтат гуа/ тохирлын тэмдэгтэй болгох.

5.1.4. Дулааны эх үүсвэртэй газруудад жилийн 4 улирлын ажиллагаатай хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нийлэг хальсан хүлэмжийн аж ахуйг сумуудад байгуулах, иргэдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх

5.1.5. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний төрөл зүйл онцлог шинж чанарын харьцуулсан судалгаа хийж тухайн бүс нутагт тохирсон шилмэл сортыг тариаланчидтайгаа хамтран сонгон тарьж ургуулах агротехнологи боловсруулж, тариалалт, үйлдвэрлэлд нэвтрүүлэх

5.1.6. Аймгийн төвд 1000 тонны багтаамжтай төмс, хүнсний ногооны механикжсан зоорь байгуулах

5.1.7. Улаанбаатар хотод 1000 тонны багтаамжтай төмс, хүнсний ногооны механикжсан зоорь байгуулах

5.1.8. Үенч сумын Цагаан эрэг, Мянгад сумын Даянхайрханы чиглэлийн услалтын систем, Дарви сумын Хойд гол, Булган сумын Давхар эрэг, Манхан сумын Улаан хүрээ, Эрдэнэбүрэнгийн услалтын системүүдийг сэргээн засварласнаар үр тариа, малын тэжээлийн ургамал, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх

5.1.9. Талбайн түүх хөтлөх, ашиглалтыг сайжруулах, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар заавар, зөвлөмжөөр хангах, орчин үеийн шинэ технологи нэвтрүүлэх

5.1.10. Бүх сум, байгууллагуудын хүн амын хүнсний ногоо, жимс жимсгэний хэрэглээг нэмэгдүүлэх, борлуулалтыг төрийн худалдан авалт /боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах, уул уурхай/-аар худалдан авалтыг дэмжүүлэх бодлого, зохицуулалтын арга хэмжээ авах, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал, зоогийн газруудад сурталчлах

5.2. Үр тариа, тэжээлийн ургамал, жимс жимсгэнэ тариалалтыг нэмэгдүүлэх, орчны дэд бүтцийг сайжруулж каластераар хөгжүүлэх зорилтын хүрээнд:

5.2.1 Жимс, жимсгэний тариалалтад дэмжлэг үзүүлж, өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.

5.2.2. Жимс, жимсгэний суулгац, тарьц үржүүлэх, эх цэцэрлэг, цуглуулгын талбай /плантаци/ “Ховд брэнд” агропаркыг Булган, Жаргалант суманд байгуулах

5.2.3. Амтат жүрж, том жимст гүзээлзгэнэ, алим, чавгыг ургуулдаг арга туршлагыг дэлгэрүүлэх, үүсгэл санаачилгыг дэмжих

5.2.4. Боловсруулалгүйгээр шууд идэх зориулалтын торниун (том) алим, чавга, интоор, бөөрөлзгөнө зэрэг хүчиллэг багатай (исгэлэн бус) жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлж жимст цэцэрлэгийн бүтцэд тэдгээрийн эзлэх хувийн жинг ихэсгэх

5.2.5. Брэнд бүтээгдэхүүн болох арвай, хөх тарианы гурилын өрхийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжиж, түүхий эдээр хангаж, борлуулалтын сүлжээг бий болгох.

5.2.6. Үенч сумын Цагаан эрэг, Мянгад сумын Даянхайрханы чиглэлийн услалтын системийг шинээр байгуулж, Дарви сумын Хойд гол, Булган сумын Давхар эрэг, Манхан сумын Улаан хүрээ, Эрдэнэбүрэний услалтын системүүдийг сэргээн засварлаж дэд бүтцийг сайжруулснаар үр тариа, малын тэжээлийн ургамлын тариалалтыг каластерээр хөгжүүлэх

5.3. Газар тариалангийн талбайнуудын услалтын системийн усан хангамжийг нэмэгдүүлэх, шинээр ус хуваарилах байгууламж байгуулж, усны алдагдлыг багасгах усалгааны системүүдийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд:

5.3.1. Дарви сумын Хойд гол, Булган сумын Давхар эрэг, Эрдэнэбүрэний услалтын системүүдийг сэргээн засварлах

5.3.2. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг өрх, фермер, жижиг аж ахуйн нэгжүүд усан сан, усалгааны системийн аль боломжтойг нь ашигладаг болгох /дуслын, намираа, бороожуулагч гэх мэт/

5.3.3. Жимс, жимсгэнэ ногооны талбай, ялангуяа хамгаалагдсан хөрсний тариаланд дуслын усалгаа, нэвчих усалгаа, мананжуулах болон бороожуулах усалгаа зэрэг ус хэмнэх сүүлийн үеийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх

5.3.4. Усалгаатай тариалан эрхэлдэг өрх бүр услалтын суваг шуудуугаа доторлох, талбайд нийлэг хальсан болон сүрлэн хучлага хэрэглэх, гадаргын усалгааны уян хоолой /хиймэл суваг/-г ашиглах, чийгийн хэмжээг хянаж зохицуулах зэргээр усны алдагдлыг багасгаж усыг хэмнэлттэй зарцуулж сургах

5.3.5. Бага хүчин чадалтай бороожуулагч төхөөрөмжийг тариаланч өрхүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх

5.3.6 Буянт сумын 108, Манхан сумын Өөшид услалтын системүүдийг шинээр барьж байгуулан үр тариа, малын тэжээлийн ургамлын тариалалтыг кластерээр хөгжүүлэх /толгойн барилга, дэд бүтэц, цахилгааны эх үүсвэрийг үе шаттайгаар шийдвэрлүүлэх/

5.3.7 Усалгааны гол болон туслах сувгийн толгойн барилга, усны хаалтыг үйлдвэрлэх иргэн аж ахуйн нэгжийг дэмжин ажиллах

5.4. Газар тариалан эрхлэгчдийн зохион байгуулах чадавхыг сайжруулах, сургалт, зөвлөгөөнд хамруулж, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зорилтын хүрээнд:

5.4.1. Хөтөлбөрт хамрагдсан тариаланчдыг хаврын тариалалтаас ургац хураалт хүртэл, мөн хөрс боловсруулах үйл ажиллагаанд “Мэргэжлийн баг”-н зүгээс хяналт тавих, зөвлөх үйлчилгээ үзүүлэх.

5.4.2. Органик гаралтай ургамал хамгааллын болон ургалтыг идэвхжүүлэгч бодис, бордоог хөтөлбөрт хамрагдсан тариаланчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх. Ургамал хамгааллын бодис эрдэс бордооны зохистой хэрэглээний сургалтыг тогтмол зохион байгуулах.

5.4.3. Орон нутгийн хэвлэлд тусгай булан нээж, газар тариалангийн мэдээллийг тогтмол нийтлэх;

5.4.4. Хамгаалагдсан хөрсний жимс, ногооны аж ахуйн чиглэлээр сургалт зохион байгуулж, харилцан туршлага судлуулах зорилгоор аймаг, орон нутагт үзүүлэх сургууль зохион байгуулах;

5.4.5. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний борлуулалтыг дэмжих, сурталчлах зорилгоор “Алтан намар” үзэсгэлэн худалдааг аймаг, сумдад зохион байгуулах;

5.4.6. Иргэд, өрхийн тариалан эрхлэгчдийг хэрэгцээт төмс, ногооны үр, жимсний суулгац, тарьцыг өөрөө үйлдвэрлэж сургахад чиглүүлэх;

5.4.7. Политехник коллежийн нөөц боломжид тулгуурлан мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх

5.4.8. Мэргэжлийн ажилтан, ажилчдыг давтан сургалтад хамруулж, чадавхжуулах. /ХХААГ, ТББ, МСҮТ, Мэргэжлийн холбоодууд/

5.4.9. Газар тариалан эрхэлдэг сумдыг бодлогоор дэмжиж мэргэжлийн агрономчдоор зайлшгүй хангах, /Алтай, Булган, Буянт, Дарви, Манхан, Үенч, Ховд, Эрдэнэбүрэн, Жаргалант/

5.5. “Ховд агропарк” зорилтот төслүүдийн хүрээнд хөдөө аж ахуйн техник дундын үйлчилгээний төв байгуулах, техникийн туслалцаа үзүүлэх “Мэргэжлийн баг” байгуулж, тариаланчдын мэргэжлийн чадавхыг сайжруулах, хяналт тавих зорилтын хүрээнд:

5.5.1. ХХАА-н газрын дэргэд техник дундын засвар үйлчилгээний төв байгуулж, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих

5.5.2. Хөтөлбөрийн дэргэд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих “Мэргэжлийн баг” байгуулах.

5.5.3. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнээр төрөл бүрийн дахин боловсруулсан шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, иргэдэд технологи, сав баглаа боодол, хаяг шошгын дэмжлэг үзүүлэх, инновац нэвтрүүлэх

5.6. Үр үржүүлгийн аж ахуй байгуулах, ургамал хамгааллын арга хэмжээг сайжруулах зорилтын хүрээнд:

5.6.1. Үр үржүүлгийн аж ахуй байгуулах

5.6.2. Арвайн “Сутай” сортын үрийн нөөцийг бий болгон, тариалалтыг нэмэгдүүлэх, тариалалтад дэмжлэг үзүүлэх

5.6.3. Болзолт уралдааныг үр үржүүлэгч нарын дунд зохион байгуулж, үйл ажиллагааг дэмжих

5.6.4. Хөрс, цаг уурт тохирсон төмс, хүнсний ногоо, үр тариа, тэжээлийн ургамлын нутагшсан сортын үр үржүүлж тариаланчдад ханган нийлүүлж, үнийн хөөргөдлийг тогтворжуулах

5.6.5. Органик бренд бүтээгдэхүүний сортын үрийг үржүүлэх /төмс, тарвас, улаан лооль, сонгино, сармис/

5.6.6. Өрхийн тариаланг дэмжих зорилгоор төмс, хүнсний ногооны үр, үрслэг, жимсний суулгац, тарьцыг хөнгөлөлттэй үнэ болон зээлээр нийлүүлэх замаар иргэдийг амьдралаа тэтгэх анхны гараанд нь дэмжлэг үзүүлэх;

5.6.7. Бутлаг хэлбэрийн алим, чавга, интоор, үхрийн нүд, гүзээлзгэний суулгацыг сонгон үржүүлэх, суулгац үйлдвэрлэх санаачилгыг дэмжин туслах, ялангуяа гүзээлзгэний том жимстэй сортын суулгацыг үржүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

5.6.8. Үр, үржүүлэгчдийн талбайд сортын хянан баталгааг жилд 2–оос доошгүй удаа хийж, үржүүлэгч нарт албан ёсны зөвшөөрөл олгох.

5.6.9 Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалангийн өвчин, хортон хог ургамалтай тэмцэхэд сонгомол үйлчилгээтэй, хүн, амьтан, байгаль орчинд хор

хөнөөлгүй, хөрс, ургамалд үлдэцгүй өндөр технологиор үйлдвэрлэсэн бодисын зөв зохистой хэрэглээг бий болгох,

5.6.10. Лооль, чинжүү болон бусад ургамлын навч, иш, тамхи зэргийг хандалж уусмал бэлтгэн хортон, шавьжтай тэмцэх экологид хор нөлөөгүй арга ажиллагаанд сургах,

5.6.11 Ховд Агропарк төслийн хүрээнд тэжээлийн ургамал түүний дотор Эрдэнэшишийн арвин ургацтай нутагшсан сортыг сонгон тариалж, үржүүлэн үрийн нөөц бий болгох, тариалах, хураах, хадгалах, боловсруулах техник хэрэгсэл худалдан авахад нь дэмжлэг үзүүлж, кластераар хөгжүүлэх

5.6.12 Чацарганы өвчин, хортонтой тэмцэх арга зүйн зөвлөгөө өгөх мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээний баг байгуулах, ургамал хамгааллын бодис, хөдөлмөр хамгааллын хувцас, техник хэрэгсэл, ажиллах нөхцөлөөр ханган дэмжлэг үзүүлэх

Зургаа: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага зохион байгуулалт, хяналт

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий салбар зөвлөл байгуулна.

6.2. Салбар зөвлөл нь хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, нэмэлт өөрчлөлт хийх, хяналт тавих үүргийг хэрэгжүүлнэ.

6.3. Дэд хөтөлбөрийг аймгийн хэмжээнд зохицуулах, мэргэжлийн арга зүйгээр удирдах үүргийг Хүнс хөдөө аж ахуйн газар хэрэгжүүлнэ.

6.4. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл арга хэмжээ, хөрөнгийг жил бүрийн аймгийн үндсэн чиглэл, төсөвт тусгахыг салбар зөвлөл хариуцан батлуулах, бусад эх үүсвэрээс хөрөнгө олж татан төвлөрүүлэх, хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын зөвлөл, холбогдох газруудад тайлагнана.

Долоо : Хөтөлбөрийн санхүүжилт

7.1. Аж ахуйн нэгж, иргэдийн өөрийн хөрөнгө

7.2. Улсын төсөв.

7.3. Тариалан эрхлэлтийг дэмжих сан

7.4. Орон нутгийн төсөв.

7.5. Банкны зээл.

7.6. Гадаад орон, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл

7.7. Гадаад, дотоодын аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгө оруулалт

7.8. Бусад эх үүсвэр.

Найм : Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

8.1. Нэг га-аас авах ургацын хэмжээ өссөн байна.

- 8.2. Усалгаатай талбайн өсөлт, нэгж талбайн ургацын хэмжээ нэмэгдсэн байна.
- 8.3. Тариалангийн салбарт шинээр бий болсон ажлын байрны тоо, өсөлт
- 8.4. Аймаг, сумын хүн амын гурил, төмс, хүнсний ногооны хангалтын хувь 8.5. Мэргэжил эзэмшүүлсэн, урт богино хугацааны сургалтад хамрагдсан мэргэжилтэн, механикжуулагч, тариаланчдын тоо.
- 8.6. Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн тооны өсөлт
- 8.7. Ургамал хамгааллын арга хэмжээг сайжруулсан байдал
- 8.8. Үр тариа, тэжээлийн ургамлын тариалалтын өсөлтийн хувь хэмжээ
- 8.9. Үр үржүүлгийн аж ахуй байгуулагдсан байх
- 8.10. Таримлын нэр төрлийн өсөлт
- 8.11. Органик брэнд бүтээгдэхүүн бий болсон байх
- 8.12. Дэд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн үр дүнг тооцохдоо тухайн жилийн байгаль цаг уурын болон эдийн засгийн байдал, зах зээлийн үнийн өсөлт зэргийг харгалзана.

Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2018	Хүрэх түвшин			
			2019	2020	2021	2022
1	Усалгаатай талбайн өсөлт /га/	2230	2300	2500	2700	3000
2	Нийт болон нэгж талбайгаас авсан ургацын хэмжээ /цн/	125	130	140	150	160
3	Үр тариа, тэжээлийн ургамлын тариалалтын өсөлт /га/	692	790	850	900	1000
4	Үр үржүүлэгчдийн тоо	0	2	5	8	12
	Таримлын нэр төрлийн өсөлт	12-14	14	18	20	24
5	Шинээр гарсан ажлын байрны тоо	-	15	30	50	80
6	Органик брэнд бүтээгдэхүүний өсөлт	2	3	4	5	6

Ес: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

9.1. Хөтөлбөрийг 2019-2022 он хүртэл хэрэгжүүлнэ.

Арав: Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ

10.1. Аймгийн салбар зөвлөл, дотоод аудитын газар хамтран хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.

10.2. Хяналт шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.



“ГАЗАР ТАРИАЛАН” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хийж гүйцэтгэх ажлын үндсэн чиглэл	Хүрэх үр дүн	Хугацаа				Төсөв / сая.төг/	Хамрах хүрээ	Хариуцах эзэн
			2019	2020	2021	2022			
Зорилт 1. Хөрс хамгаалах технологийг нэвтрүүлж, төмс, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуйн тариалалтыг нэмэгдүүлэх, хадгалах нөхцөлийг сайжруулж худалдан борлуулах									
1.1	Тариалангийн талбайг хөрсний элэгдэл, эвдрэлээс хамгаалж ойн зурвас байгуулах, хөрс хамгаалах технологийг нэвтрүүлэх.	Тариалангийн талбайг хөрсний элэгдэл, эвдрэлээс хамгаалж, жилд 10-аас доошгүй га талбайд ойн зурвас байгуулагдана.	+	+	+	+	15,0	ХХААГ, Мэргэжлийн холбоод, ААН, газар тариалан эрхлэгчид,	ХХААГ, Мэргэжлийн холбоод
1.2	Шинэ төрлийн таримал ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх. /салат, цэцэгт, броколи байцаа, сармис, амтат болон гашуун чинжүү, үнэрт, навчит ногоо/	Шинэ төрлийн 10 гаруй таримал нэмэгдэнэ.	+	+	+	+	80,0	ХХААГ, Мэргэжлийн холбоод, ААН, газар тариалан эрхлэгчид	ХХААГ, Мэргэжлийн холбоод
1.3	Ховдын органик брэнд бүтээгдэхүүн буй болгох, уламжлалт нэрийн бүтээгдэхүүнийг /тарвас, төмс, сармис, арвайн /Сутай сорт/, амтат гуа /тохирлын тэмдэгтэй болгох.	Брэнд бүтээгдэхүүний тоо нэмэгдэж, зарим бүтээгдэхүүний тохирлын тэмдэгтэй болсон байна.	+	+	+	+	12,0	ЗДТГ, ХХААГ, сумын ЗДТГ, ХАА-н тасаг газар тариалан эрхлэгчид	ЗДТГ, ХХААГ, сумын ХАА-н мэргэжилтэн
1.4	Дулааны эх үүсвэртэй газруудад жилийн 4 улирлын ажиллагаатай хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	3 улирлын нарлаг хүлэмж эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж, жилд 2-оос доошгүйг байгуулсан байна.	+	+	+	+	48,0	ЗДТГ, ХХААГ, сумын ХАА-н мэргэжилтэн, газар тариалан эрхлэгчид	ХХААГ, сумын ХАА-н мэргэжилтэн
1.5	Зуны нийлэг хальсан хүлэмжийн аж ахуйг сумуудад байгуулах, нийлэг хальсан хүлэмжийг иргэдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх	Сумуудад нийлэг хальсан 1-2 хүлэмж хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэгдэнэ.	+	+	+	+	28,8	ХХААГ, сумын ХАА-н мэргэжилтэн, газар тариалан эрхлэгчид	ХХААГ, сумын ХАА-н тасаг
1.6	Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний төрөл зүйл онцлог шинж чанарын харьцуулсан судалгаа хийж тухайн бүс нутагт тохирсон шилмэл сортыг тариаланчтайгаа хамтран сонгон тарьж ургуулах агротехнологи боловсруулж, тариалалт, үйлдвэрлэлд	Бүс нутгийн онцлогт тохирсон 1-2 сорт судалгаанд хамрагдаж, ургуулах технологи боловсруулагдана.	+	+	+	+	42,0	ЗДТГ, ХХААГ, сумын ХАА-н мэргэжилтэн, газар тариалан эрхлэгчид	ХХААГ, сумын ХАА-н тасаг

	нэвтрүүлэх									
1.7	Аймгийн төвд 1000 тонны багтаамжтай төмс, хүнсний ногооны механикжсан зoorь байгуулах	Төмс, хүнсний ногооны механикжсан зoorьтой болно.	+					600,0	ЗДТГ, ХХААГ, Жаргалант сумын газар тариалан эрхлэгчид	ЗДТГ, ХХААГ, Жаргалант сум
1.8	Улаанбаатар хотод 1000 тонны багтаамжтай төмс, хүнсний ногооны механикжсан зoorь байгуулах	Төмс, хүнсний ногооны механикжсан зoorьтой болж Ховд аймгийн тариаланчдын ногоог хадгалж борлуулдаг болно.		+	+			1200,0	ЗДТГ, ХХААГ, газар тариалан эрхлэгчид	Нутгийн зөвлөл, ЗДТГ, ХХААГ, ТББ
1.9	Үенч сумын Цагаан түнгэ, Дарви сумын Хойд гол, Булган сумын Давхар эрэг, Манхан сумын Улаан хүрээ, Эрдэнэбүрэний услалтын системүүдийг сэргээн засварлаж үр тариа, малын тэжээлийн ургамал, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх	Услалтын системүүдийг сэргээн засварлаж, үр тариа, тэжээлийн ургамал, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалт нэмэгдэнэ.	+	+	+	+		4000,0	ЗДТГ, ХХААГ, сумын ЗДТГ, ХАА-н тасаг газар тариалан эрхлэгчид	ЗДТГ, ХХААГ, сумын ХАА-н тасаг
Зорилт 2. Үр тариа, тэжээлийн ургамал, жимс жимсгэнэ тариалалтыг нэмэгдүүлэх, орчны дэд бүтцийг сайжруулж кластераар хөгжүүлэх:										
2.1	Жимс, жимсгэний тариалалтад дэмжлэг үзүүлж, өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.	Жимс, жимсгэний тариалалт, үйлдвэрлэл нэмэгдэнэ.	+	+	+	+		51,0	ЗДТГ, ХХААГ, сумын ЗДТГ, ХАА-н тасаг газар тариалан эрхлэгчид	ЗДТГ, ХХААГ, сумын ХАА-н тасаг
2.2	Жимс, жимсгэний суулгац, тарьц үржүүлэх, эх цэцэрлэг, цуглуулгын талбай/плантаци/ "Ховд брэнд" агропаркыг Булган, Жаргалант суманд байгуулах	Жаргалант, Булган сумуудад жимс, жимсгэний эх цэцэрлэг, агропаркууд байгуулагдаж, Ховд брэндийн тоо нэмэгдэнэ.	+	+	+	+		1,200,0	ЗДТГ, ХХААГ, Булган, Жаргалант сумын ЗДТГ, ХАА-н тасаг газар тариалан эрхлэгчид	ЗДТГ, ХХААГ, сумын ХАА-н тасаг
2.3	Боловсруулалгүйгээр шууд идэх зориулалтын торниун (том) алим, чавга, интоор, үхрийн нүд зэрэг хүчиллэг багатай (исгэлэн бус) жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлж жимст цэцэрлэгийн бүтцэд тэдгээрийн эзлэх хувийн жинг ихэсгэх	Алим, чавга, интоор, үхрийн нүд зэрэг жимс жимсгэний тариалалт нэмэгдэнэ.	+	+	+	+		276,7	ХХААГ, сумын ЗДТГ, ХАА-н тасаг, газар тариалан жимс, жимсгэнэ тариалагчид	ХХААГ, сумын ХАА-н тасаг
2.4	Брэнд бүтээгдэхүүн болох арвай, хөх тарианы гурилын өрхийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжиж, түүхий эдээр хангаж, борлуулалтын сүлжээг бий болгох.	Үр тарианы тариалалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэж, борлуулалтын сүлжээтэй болсон байна.	+	+	+	+		60,0	ЗДТГ, ХХААГ, сумын ЗДТГ, ХАА-н тасаг газар тариалан эрхлэгчид	ЗДТГ, ХХААГ, сумын ХАА-н тасаг
2.5	Усалтын системүүдийг түшиглэн үр тариа, малын тэжээлийн ургамлын тариалалтыг каластерээр хөгжүүлж тариалалтыг нэмэгдүүлэх	Үр тариа, малын тэжээлийн ургамлын тариалалтыг жил бүр 10-аас дээш хувиар нэмэгдүүлсэн байна.	+	+	+	+		300,0		
Зорилт 3. Газар тариалангийн талбайнуудын услалтын системийн усан хангамжийг нэмэгдүүлэх, шинээр ус хуваарилах байгууламж байгуулж, усны алдагдлыг багасгах усалгааны системүүдийг нэвтрүүлэх;										
3.1	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ	Усалгааны дэвшилтэт	+	+	+	+		57,0	ЗДТГ, ХХААГ, сумын	ЗДТГ, ХХААГ,

	тариалдаг өрх, фермер, жижиг аж ахуйн нэгжүүд усан сан, услалтын системийн аль боломжтойг нь ашигладаг болгох /дуслын, намираа, бороожуулагч гэх мэт/	технологийг дэлгэрүүлнэ.							ЗДТГ, ХАА-н тасаг газар тариалан эрхлэгчид	сумын ХАА-н тасаг
3.2	Хамгаалагдсан хөрсний тариаланд дуслын усалгаа, нэвчих усалгаа, мананжуулах болон бороожуулах усалгаа зэрэг ус хэмнэх сүүлийн үеийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх.	Усны хэмнэлттэй технологийг нэвтрүүлнэ.	+	+	+	+	60,0			
3.3	Усалгаатай тариалан эрхэлдэг өрх бүр услалтын суваг шуудуугаа доторлох, талбайд нийлэг хальсан болон сүрлэн хучлага хэрэглэх, гадаргын усалгааны уян хоолой /хиймэл суваг/-г ашиглах, чийгийн хэмжээг хянаж зохицуулах зэргээр усны алдагдлыг багасгаж усыг хэмнэлттэй зарцуулж сургах	Өрхийн тариалан эрхлэгчид усны алдагдлыг багасгаж, усыг хэмжилттэй зарцуулдаг аргыг эзэмшсэн байна.	+	+	+	+	40,0			
3.4	Буянт сумын 108, Манхан сумын Өөшид услалтын системүүдийг шинээр барьж байгуулан үр тариа, малын тэжээлийн ургамлын тариалалтыг кластерээр хөгжүүлэх /толгойн барилга, дэд бүтэц, цахилгааны эх үүсвэрийг үе шаттайгаар шийдвэрлүүлэх/	Буянт сумын 108, Манхан сумын Өөшид услалтын системүүдийн толгойн барилга, дэд бүтэц, цахилгааны эх үүсвэрийг үе шаттайгаар шийдвэрлүүлсэн байна.		+	+	+	1000,0		ЗДТГ, ХХААГ, сумын ЗДТГ, ХАА-н тасаг газар тариалан эрхлэгчид	ХХААГ, сумын ЗДТГ, ХАА-н тасаг
3.5	Усалгааны гол болон туслах сувгийн толгойн барилга, усны хаалтыг үйлдвэрлэх иргэн аж ахуйн нэгжийг дэмжин ажиллах	Усалгааны гол болон туслах сувгийн толгойн барилга, усны хаалтыг үйлдвэрлэдэг сонгож дэмжлэг үзүүлдэг болсон байна		+	+	+	120,0			
Зорилт 4. Газар тариалан эрхлэгчдийн зохион байгуулах чадавхыг сайжруулах, сургалт, зөвлөгөөнд хамруулж, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах										
4.1	Хөтөлбөрт хамрагдсан тариаланчдыг хаврын тариалалтаас ургац хураалт хүртэл, мөн хөрс боловсруулах үйл ажиллагаанд "Мэргэжлийн баг"-н зүгээс хяналт тавих, зөвлөх үйлчилгээ үзүүлэх.	Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.	+	+	+	+	20,0		ЗДТГ, ХХААГ, сумын ЗДТГ, ХАА-н тасаг газар тариалан эрхлэгчид	ХХААГ, Хөгжил политехник коллеж
4.2	Органик гаралтай ургамал хамгааллын болон ургалтыг идэвхжүүлэгч бодис, бордоог хөтөлбөрт хамрагдсан тариаланчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх. Химийн бодис, бордоог хэрэглэхийг хориглох.	Бордоо, ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээ нэвтэрсэн байна.	+	+	+	+	80,0			ХХААГ, Хөгжил политехник коллеж
4.3	Орон нутгийн хэвлэлд тусгай булан нээж, газар тариалангийн мэдээллийг тогтмол нийтлэх;	Газар тариалангийн мэдээлэл тогтмолжсон байна.	+	+	+	+	2,0			ХХААГ
4.4	Хамгаалагдсан хөрсний жимс, ногооны аж	Тариалан эрхлэгчдийн	+	+	+	+	40,0			ХХААГ, сумын

	ахуйн чиглэлээр сургалт зохион байгуулж, харилцан туршлага судлуулах зорилгоор аймаг, орон нутагт үзүүлэх сургууль зохион байгуулах;	хамгаалагдсан хөрсний аж ахуйн мэдлэг мэдээлэл дээшилж чадавхажсан байна.								ХАА-н тасаг
4.5	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний борлуулалтыг дэмжих, сурталчлах зорилгоор “Алтан намар” үзэсгэлэн-худалдааг аймаг, сумдад зохион байгуулах;	Үзэсгэлэн худалдаа, сурталчилгааны ажил тогтмолжсон байна.	+	+	+	+		12,0		ЗДТГ, ХХААГ, сумын ХАА-н тасаг
4.6	Иргэд, өрхийн тариалан эрхлэгчдийг хэрэгцээт төмс, ногооны үр, жимсний суулгац, тарьцыг өөрөө үйлдвэрлэж сургахад чиглүүлэх;	Жимс, жимсгэний тариалалт, үйлдвэрлэл нэмэгдэнэ.	+	+	+	+		20,0		ХХААГ, сумын ХАА-н тасаг Хөгжил политехник коллеж
4.7	Политехник коллежийн нөөц боломжид тулгуурлан мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх	Мэргэжилтэй ажилчин бэлтгэгдэнэ.	+	+	+	+			ЗДТГ, ХХААГ, сумын ЗДТГ, ХАА-н тасаг Хөгжил политехник коллеж, газар тариалан эрхлэгчид	ХХААГ, Хөгжил политехник коллеж
4.8	Мэргэжлийн ажилтан, ажилчдыг давтан сургалтад хамруулж, чадавхжуулах. /ХХААГ, ТББ, МСҮТ, Мэргэжлийн холбоодууд/	Газар тариалан эрхлэгчид давтан сургалтад хамрагдана.	+	+	+	+				
4.9	Газар тариалан эрхэлдэг сумдыг бодлогоор дэмжиж мэргэжлийн агрономчдоор зайлшгүй хангах, /Алтай, Булган, Буянт, Дарви, Манхан, Үенч, Ховд, Эрдэнэбүрэн, Жаргалант /	Сумын ХАА-н тасгууд мэргэжлийн боловсон хүчин агрономчдоор хангагдсан байна.	+	+	+	+			ЗДТГ, ХХААГ, сумын ЗДТГ, ХАА-н тасаг	ХХААГ, сумдын ЗДТГ
Зорилт 5. “Ховд агропарк” зорилтот төслүүдийн хүрээнд хөдөө аж ахуйн техник дундын үйлчилгээний төв байгуулах, техникийн туслалцаа үзүүлэх “Мэргэжлийн баг” байгуулж, тариаланчдын мэргэжлийн чадавхыг сайжруулах, хяналт тавих										
5.1	ХХААГ-н дэргэд техник дундын засвар үйлчилгээний төв байгуулж, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгжийг зээл тусламжид хамруулж, дэмжин ажиллах	Газар тариалангийн үйлдвэрлэлд шинэ дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлсэн байна.	+	+	+	+		80,0	ЗДТГ, ХХААГ, сумын ЗДТГ, ХАА-н тасаг газар тариалан эрхлэгчид	ХХААГ, сумын ХАА-н тасаг Хөгжил политехник коллеж
5.2	Хөтөлбөрийн дэргэд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих “Мэргэжлийн баг” байгуулах.	Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байна.	+	+	+	+		6,0		ХХААГ, Хөгжил политехник коллеж
5.3	Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнээр төрөл бүрийн дахин боловсруулсан шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, иргэдэд технологи, сав баглаа боодол, хаяг шошгын дэмжлэг үзүүлэх, инноваци нэвтрүүлэх	Шинэ дэвшилтэт технологи нэвтэрч, сав баглаа боодол, хаяг шошготой болсон байна.	+	+	+	+		40,0		ХХААГ, Хөгжил политехник коллеж
Зорилт 6. Үр үржүүлгийн аж ахуй байгуулах, ургамал хамгааллын арга хэмжээг сайжруулах										
6.1	Үр үржүүлгийн аж ахуй байгуулах	Үрийн аж ахуй байгуулагдана.	+	+	+	+		120,0	ЗДТГ, ХХААГ, сумын ХАА-н мэргэжилтэн, газар тариалан эрхлэгчид, үр үржүүлэгчид	ХХААГ, Хөгжил политехник коллеж, үр үржүүлэгчид
6.2	Арвайн “Сутай” сортын үрийн нөөцийг бий болгон, тариалалтыг нэмэгдүүлэх, тариалалтад дэмжлэг үзүүлэх	Арвайн “Сутай” сортын үрийн сантай болно.	+	+	+	+		8,5		
6.3	Болзолт уралдааныг үр үржүүлэгч нарын	Үр үржүүлэгчдийн үйл	+	+	+	+		4,0		

	дунд зохион байгуулж, үйл ажиллагааг дэмжих	ажиллагаа дэмжигдсэн байна.									
6.4	Хөрс, цаг уурт тохирсон нутагшсан сортын үр үржүүлж тариаланчдад ханган нийлүүлж, үнийн хөөрөгдлийг тогтворжуулах	Бүсийн онцлогт тохирсон нутагшсан сортын үр үржүүлэгдэж, үрээр хангагдана.	+	+	+	+		22,0			
6.5	Органик брэнд бүтээгдэхүүний сортын үрийг үржүүлэх/ төмс, тарвас, улаан лооль, сонгино, сармис/	Брэнд таримлуудын үр үржүүлэгдэж, хангамж нэмэгдсэн байна.	+	+	+	+		14,0			
6.6	Үр, үржүүлэгчдийн талбайд сортын хянан баталгааг жилд 2 –оос доошгүй удаа хийж, үржүүлэгч нарт албан ёсны зөвшөөрөл олгох.	Үр үржүүлгийн талбайд хянан батлагч нар хийж, тусгай зөвшөөрөл олгоно.	+	+	+	+		6,0			
6.7	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалангийн өвчин, хортон хог ургамалтай тэмцэхэд сонгомол үйлчилгээтэй, хүн, амьтан, байгаль орчинд хор хөнөөлгүй, хөрс, ургамалд үлдэцгүй өндөр технологиор үйлдвэрлэсэн бодисын зөв зохистой хэрэглээг бий болгох,	Бордоо, ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээ нэвтэрсэн байна.	+	+	+	+		14,0			
6.8	Лооль, чинжүү болон бусад ургамлын навч, иш, тамхи зэргийг хандалж уусмал бэлтгэн хортон, шавьжтай тэмцэх экологид хор нөлөөгүй арга ажиллагаанд сургах	Биологийн уусмалыг бэлтгэж, хэрэглэх аргыг эзэмшсэн байна.	+	+	+	+		12,0			
6.9	Ховд Агропарк төслийн хүрээнд тэжээлийн ургамал түүний дотор Эрдэнэшишийн арвин ургацтай нутагшсан сортыг сонгон тариалж, үржүүлэн үрийн нөөц бий болгох, тариалах, хураах, хадгалах, боловсруулах техник хэрэгсэл худалдан авахад нь дэмжлэг үзүүлж, кластераар хөгжүүлэх	Ховд Агропарк төслийн хүрээнд тэжээлийн ургамал түүний дотор Эрдэнэшишийн арвин ургацтай нутагшсан сортыг үрийн нөөцтэй болж, техник технологийн дэмжлэг үзүүлсэн байна.	+	+	+	+		300,0			
6.10	Чацарганы өвчин, хортонтой тэмцэх арга зүйн зөвлөгөө өгөх мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээний баг байгуулах, ургамал хамгааллын бодис, хөдөлмөр хамгааллын хувцас, техник хэрэгсэл, ажиллах нөхцөлөөр ханган дэмжлэг үзүүлэх	Ургамал хамгааллын цогц арга хэмжээ боловсруулагдаж үйлдвэрлэлд нэвтэрсэн байна.	+	+	+	+		50,0			
Нийт санхүүжилт								8,841,0			

ЗДТГ, ХХААГ, сумын ХАА-н мэргэжилтэн, газар тариалан эрхлэгчид, үр үржүүлэгчид

ЗДТГ, ХХААГ, газар тариалан эрхлэгчид, үр үржүүлэгчид

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны
20 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт



“Газар тариалан” хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн
салбар зөвлөлийн бүрэлдэхүүн

- Салбар зөвлөлийн дарга: - Аймгийн Засаг даргын Эдийн засаг үйлдвэрлэл дэд бүтэц хариуцсан орлогч
- Гишүүд:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү Төрийн сангийн хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний албаны дарга
 - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний албаны мэргэжилтэн
 - Сумдын Засаг дарга нар
 - Аймгийн агрономичдын холбооны төлөөлөл
 - Мэргэжлийн холбоодуудын төлөөлөл
 - Тариаланч, ногоочдын төлөөлөл
- Нарийн бичгийн дарга: - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

--oOo--